

## ТАНИЛЦУУЛГА

“Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн тухай

Төслийн хэрэгцээ: Улаанбаатар хотын хүн амын өсөлтөөс шалтгаалан үүсэж буй хог хаягдлын хэмжээ эрс нэмэгдэж байгаагаас ойрын ирээдүйд хогийн цэгүүд дүүрэх, даац нь хэтрэхээр байна. Мөн сүүлийн жилүүдэд барилга, байгууламжийн нураалтын хог хаягдал зохицуулалтгүй хаягдаж, цаашид хуучны барилга байгууламжуудыг нураахад хатуу хог хаягдлыг дахин боловсруулж барилгын материал дахин үйлдвэрлэх, байгаль орчны бохирдлоос сэргийлэх шаардлага үүсээд байна.

Хийгдэх ажил: Төслийн хүрээнд Европын холбооны стандарт шаардлагыг хангах, хатуу хог хаягдлыг булшлах цэг (“ландфил”) болон барилгын хог хаягдлыг дахин боловсруулах байгууламжийг Морингийн даваанд барихаар төлөвлөж байна. Мөн хатуу хог хаягдлын салбарт нэгдсэн тариф нэвтрүүлэх, барилга болон барилга нураалтын хог хаягдлын менежментийн зохицуулалтыг бий болгох ажлууд төслийн хүрээнд хийгдэнэ.

Нийгэм, эдийн засгийн үр өгөөж: Төслийг хэрэгжүүлснээр хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйлчилгээг шинэчлэн, хог хаях цэгүүдийн хүчин чадлыг дөрвөн сая тонноор нэмэгдүүлнэ. Мөн Улаанбаатар хотод ялгарч буй хүлэмжийн хий (CO<sub>2</sub>)-н хэмжээг жилд 18,000 тонноор бууруулж, 100,000 тонн гаруй барилгын хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Төслийн санхүүжилт: Төслийн нийт өртөг 16.7 сая ам.доллар байхаас ЕСБХБ-наас 2.0 сая ам.долларын техник туслалцаа, 5 сая ам.долларын буцалтгүй тусламж, 9.7 сая ам.долларын зээлийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газарт олгохоор тохиролцоод байна.

Зээлийн нөхцөл нь:

Зээлийн хэмжээ /ам.доллар/:	9.7 сая
Зээлийн хугацаа:	15 жил
Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа:	3 жил
Жилийн хүү /хувьсагч хүү/:	LIBOR+1%

Төслийн хүрээнд зээлийн санхүүжилтийн хамт олгож буй буцалтгүй тусламжийн санхүүжилтийг оруулан тооцоолоход зээлийн хөнгөлөлтийн түвшин /ОУВС-ийн тооцооллоор/ 43.06 хувь байгаа нь нэн хөнгөлөлттэй зээлийн ангилалд хамаарч байна.

Төслийн зээлийн болон буцалтгүй тусламжийн хэлэлцээрүүдийг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулагдах ЕСБХБ-ны Захирагч нарын жилийн уулзалтын үеэр байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн дэд сайд гарын үсэг зурахаар төлөвлөж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР